

БАЯНТАЛ СУМЫН 2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

2024.10.24

Баянтал сум

Нэг. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Сумын удирдах ажилтны шуурхай хурлыг 1 удаа, дотоод хурлыг 7 хоног болгоны 1 өдөр хуралдаж үүрэг даалгаврыг сумын Засаг дарга болон, ЗДТГ-н дарга нараас өгсөн төрлийн үүрэг даалгаврыг тухай бүр хариуцсан албан хаагчдад дамжуулан өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан.

2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит 20 дугаар хуралдаанаар 5 асуудал хэлэлцэхээс 1 асуудал татуулж, 4 асуудлыг шийдвэрлэж батлуулсан.

2024 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуулийг сумын 1, 2 дугаар хэсгийн хороон дээр санал авах үйл ажиллагааг зохион байгуулж, сумын сонгуулийн хороонд 23 албан хаагчид оролцож ажилласан. Баянтал сумын хэмжээнд 731 хүн санал өгөхөөс 575 иргэн саналаа өгч, ирц 78.15%-тай хамрагдсан байна.

Цэрэг татлага:

2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр “Цэргийн жинхэнэ албаны 2 дугаар ээлжийн цэрэг татлага” сумын иргэний танхимд зохион байгуулагдлаа. Цэрэг татлагат аймгийн Цэргийн штаб, аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэргэжлийн эмч нар, цэргийн татлагыг зохион байгуулах сумын ажлын хэсэг ажилласан. Нийт 2 багийн цэргийн албанд татагдах 32 иргэд байх бөгөөд үүнээс гадаадад оршин суудаг, оюутан, ажил эрхэлж байгаа, эрүүл мэндийн шалтгаанаар цэргийн алба хаах боломжгүй иргэд хасагдаж, үзлэгээр 14 хүн хамрагдаж үүнээс 2 хүн цэргийн алба хаахаар болсон.

Цахим мэдээлэл: “Говьсүмбэр аймгийн Баянтал сум” фэйсбүүк групп хуудсанд нийт 57 мэдээлэл оруулсан үүний 25 ведио, 32 зурган мэдээлэл байна. Аймгийн хэмжээнд болж буй цаг үеийн мэдээ, мэдээлэл, ажлын байр, арга хэмжээ гэх мэдээллүүдийг тогтмол шэйр хийж түгээж ажилласан байна.

Мөн Онцгой байдлын ерөнхий газар болон Цаг уур орчны шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээ 3 шейрлэж ажилласан.

Лүн баг, Их уул багийн Засаг дарга цэргийн зарлан хүргэж, өвөлжилтийн өвс тэжээлийн судалгааг авч ажилласан.

Төрийн үйлчилгээний ХУРДАН цэгээс <https://operator.e-mongolia.mn/dashboard> системээр 09 сарын 25 наас 10 сарын 21-ны хүртэл нийт 54 лавлагаа мэдээлэл гаргаж ажилласан. Үүнээс:

- ❖ Иргэний үнэмлэхийн лавлагаа – 12
- ❖ Оршин суугаа хаягын тодорхойлолт - 12
- ❖ Үл хөдлөх хөрөнгөний лавлагаа – 1
- ❖ Гэрлэсний бүртгэлийн лавлагаа – 4
- ❖ Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа - 1
- ❖ Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа – 9
- ❖ Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй эсэх тодорхойлолт – 7
- ❖ Мал тооллогын лавлагаа – 5
- ❖ Малчны тодорхойлолт - 3

Хоёр. ТӨСӨВ САНХҮҮГИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Орлогын биелэлт: 2024 оны 10 дугаар сарын 06-ны байдлаар 149,945.0 мянган төгрөг төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлээр 301,319.5 мянган төгрөг буюу 200.9 хувиар орлогыг давуулан биелүүлсэн байна. Баянтал сумын нэгтгэлийн /ОН/ өглөг 2,893.6 мянган төгрөг , авлага 4,341.9 мянган төгрөг байна.

Шилэн данс: Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 10 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. 01-10 дугаар сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдал 85 хувьтай байна.

10 дугаар сарын орлого:

1. Говьсүмбэр, Баянтал Суутган 10.777.352.33
 2. Говьсүмбэр, Баянтал Хувь хүний АТ- 132,400,00
 3. Говьсүмбэр, Баянтал Газрын төлбөр 74.807.00
 4. Говьсүмбэр, Баянтал ҮХЭХАТ- 2.393,00
 5. Говьсүмбэр, Баянтал Улсын тэмдэгтийн хураамж 1,114,100
 6. Говьсүмбэр, Баянтал Агнуурийн нөөцийн төлбөр 4,019,400,00
 7. Говьсүмбэр, Баянтал иргэн ҮХХБАТ 809,600,00
 8. Говьсүмбэр, Баянтал Хадгаламжийн хүү орлого 1,354,282,69
- Нийт: 18,284,335,02

Гурав. НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

- Байгууллагууд харьяалалтай ахмадууддаа хүндэтгэл үзүүлж ажиллаа.
- Орон нутагтаа олон жил үр бүтээлтэй ажилласан ахмадууддаа “Говьсүмбэрийн төлөө” медаль, аймаг, сумын 30 жилийн ойн хүндэт тэмдэгийг гардуулсан.
- Сумын ахмадын баяр тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулж нийт 80 ахмад хамрагдсан. Тус арга хэмжээгээр 6 төрлийн тэмцээн уралдааныг зохион байгуулсан. Нийт ахмадын баяр тэмдэглэхэд төсөв Засаг даргын нөөц хөрөнгөөс 1.346.000, тамгын газрын харьяат ахмадыг хүлээж авахад нэг удаагийн тэтгэмжээс 540,000 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.
- Тус суманд Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас иргэд эцэг эхчүүдэд хүүхэд хамгааллын тухай хуульд орсон өөрчлөлт, цаашид анхаарвал зохих асуудлуудын талаар мэдээлэл өгөхөд 45 хүн хамрагдсан.

Дөрөв. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

2024-2025 оны хөдөө аж ахуйн, төв суурийн газрын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангуулах ажлын хэсгийг сумын орлогч аргаар ахлуулсан 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, сумын өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын төлөвлөгөөг батлуулан ажилласан.

2024 оны 10 сарын 21-ны байлаар Малчин өрхийн түвшинд 585 тн өвс, 32,5 тн ногоон тэжээл, 6,2 тн гар тэжээл бэлтгэсэн байна.

Сумын ИТХурлаар “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох тов зарлуулж 10 сард ХХСангаас зээл олгоно. ХХСан 98.000.000,00 төгрөгийн үлдэгдэлтэй

байна. Хошоо хөгжүүлэх сан нь өнөөдрийн байдлаар 7 зээлдэгч 130.290.410 төгрөгийн авлагатай. Үүнээс хэвийн зээлдэгч 72,000,000.00 төгрөгийн үлдэгдэлтэй, хугацаа хэтэрсэн 58,290,410 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Эхний 9 сарын байдлаар зээлийн эргэн төлөлт 57,5 хувь

Мал эмнэлэг: Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 68 өрхийн 2139 үхэр, Цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 62 өрхийн 15190 хонь, хурга, мөн 8 сарын 15-нөөс эхлэн угаалгын явцад 20 гаран өрх хамрагдсан. 10 сард бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 37 өрхийн хонь 70783, ямаа 850, нийт 71633 толгой мал хамрагдсан байна.

Хөдөлмөр, Халамж үйлчилгээний чиглэлээр:

2024 оны 10-р сарын 01-ээс 2024 оны 10-р сарын 21-ний өдрийн байдлаар Хөдөлмөр эрхлэлт болон халамжийн үйлчилгээг нийт 45 иргэнд үзүүлж, нийгмийн халамжийн 8 төрлийн үйлчилгээг 34 иргэнд хүргэсэн байна. Үүнд:

1. Хүүхдийн мөнгөн тэтгэмж-2
2. Цалинтай ээж-1
3. Амралт сувиллын эрхийн бичиг-1
4. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн-4
5. Ахмад настны асаргаа сунгалт-4
6. Орон сууцны болон түлээ нүүрсний үнийн хөнгөлөлт-10
7. Хиймэл шүдний хөнгөлөлт-1
8. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд-10 иргэнд тус тус үйлчилсэн байна.

Тав. ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд Намрын мод тарилтаар буюу 2024 оны 10-р сарын 04-ний өдөр нийт 1000 ширхэг мод тарьсан. Үүнд Шар хуайс 800 ширхэг, Голт бор 100 ширхэг, Агч 100 ширхэг тус тус суулгасан. Тус ажилд төрийн 5 байгууллага, 1 ОНӨААТҮГ, хувь хүн айл өрхийн нийлсэн 70 гаруй хүн хамрагдаж оролцсон.

Аймгийн БОАЖГ-т иргэдийн өгсөн хүсэлтийн дагуу 2024.10.14-ний өдөр суманд шинээр мод тарьж ургуулсан 6-н айл өрхөөр орж модны тооллого хийсэн. Энэ жил тоолсон модны урамшуулал мөнгө 2025 оны намар олгогдоно.

Зургаа. ДЭД БҮТЭЦ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Гамшгаас хамгаалах чиглэлээр:

- ✓ “Гамшгийн эрсдлийг бууруулах олон улсын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан “Хэн ч хэзээ ч хаана ч бэлэн” арга хэмжээг зохион байгуулан ЗДТГ, ЕБСургууль, Цэцэрлэг, Талын илч ХХК, ЭМТөвийн албан хаагчид бүрэн хамрагдан оролцсон. Буухиа тэмцээн зохион байгуулагдаж тэргүүн байр “Талын Илч” ОНӨҮГ, дэд байр ЗДТГ, гутгаар байр Сургуулийн хамт олон тус тус эзэллэсэн.

- ✓ 2024 оны 10 дугаар сарын 19-нд 14-р зөрлөгийн уурхайн самбарын хажууд хээрийн түймэр гарсан дуудлагын дагуу сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангиас 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр явж ажиллаа.
- ✓ 2024 оны 10 сарын 20-ны өдрийн шуурганд 2 хүн төөрсөн дуудлагын дагуу гамшгаас хамгаалах мэргэжлийн анги ЗДТГ-н ажилчид, ЭМТ-н хамтран ажиллаж төөрсөн 2 хүний олж, шуурганд уруудсан малыг хашиж. Мөн ЗДТГазраас цаг агаарын мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлэгийг тухай бүр цахим сайт, группээр өгч ажиллаж байна.

Баянтал сумын 2024 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр

Спорт заалны барилга шинээр барих тендер 2024 оны 07-р сарын 18-ны өдөр амжилттай зарлагдаж “Хур билэг” ХХК шалгарч 2024 оны 08-р сарын 26-ны өдөр гэрээ байгуулсан. /Гэрээний мөнгөн дүн 595,283,449 төгрөг/

Цагдаагийн хэсэг:

Сум дүүрэг, иргэдийн төлөөлөгчдийн санал авах 6-2-1, 6-2-2 дэх сонгуулийн байрыг 24 цагаас мөн сонгуулийн тоног төхөөрөмжийн хамгаалалтад 4 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан. Уг хугацаанд иргэд байгууллагаас 14 дуудлага мэдээлэл ирсэнээс зам тээврийн ослын шинжтэй 7, ахуйн гэр орон сууцны дуудлага мэдээлэл 2, хулгайлах дуудлага мэдээлэл 2 ирсэнээс хандалт 3 ирсэн 1 гомдол мэдээллийг харьяаллын бус учир шилжүүлсэн, Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 5 зөрчил илрүүлсэн 4 шийдвэрлэсэн 1 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй, “Хянамгай байя” арга хэмжээний хүрээнд эрэн сурвалжлагдаж буй 2 этгээдийг олж илрүүлсэн, Хэрэг бүртгэлтийн 7 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа хийж 2 хэргийг эрүүгийн хэрэгт татаж яллагдагчаар татах саналтай прокурорын хяналтад хүргүүлэв.

ЗДТГазраас ЕБСургууль-2, ЭМТөвд 2, цэцэрлэг 2, соёлын төвд 1 нийт 7 камер өгч байршуулсан.